

“ХОРГО ХАЙРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр
сарын 27-ний өдөр

№1

Улаанбаатар
хот

Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх зүйл, “Хорго Хайрхан” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2017 оны жилийн эцсийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч, баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ГАНЧИМЭГ

“ХОРГО ХАЙРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр
сарын 27-ний өдөр

№2

Улаанбаатар
хот

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дох заалт, “Хорго Хайрхан” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Хорго Хайрхан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд кумулятив санал хураалтын аргаар олонхийн санал авсан

1. Ц. Ганчимэг
2. Т. Батзул
3. Д. Мөнхбат
4. М. Чингүүн
5. Я. Энхбаяр
6. Ч. Энх-Амгалан нарыг;

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд кумулятив санал хураалтын аргаар олонхийн санал авсан

1. Ц. Цэндмаа
2. Б. Аюуш
3. Ц. Мандулай нарыг тус тус сонгосугай

ХУРЛЫН ДАРГА



Ц.ГАНЧИМЭГ

“ХОРГО ХАЙРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр
сарын 27-ний өдөр

№3

Улаанбаатар
хот

Компанид “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах болон бусад асуудлыг батлах тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 4; 17; 18; 20; 38; 53; 54; 62; 87; 88; 89; 92, “Иргэний хууль”-ийн 31 дүгээр зүйлийн холбогдох заалтууд, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 3.1. дэх хэсэг, 5.3. дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2018 оны 2018/01 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон “Хорго Хайрхан” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанид “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэж, түүний эрх үүрэг, хариуцлагыг “Хорго Хайрхан” ХК-д шилжүүлэн өөрчлөн зохион байгуулсугай.
2. Нэгдэж буй “Монгол Даатгал” компанийн оноосон нэрийг өөрчлөн байгуулагдсан компанид үргэлжлүүлэн хэрэглэхийг зөвшөөрч, “Хорго Хайрхан” ХК-ийн оноосон нэрийг “Монгол Даатгал” ХК болгохыг зөвшөөрсүгэй.
3. Компанийг нэгтгэх үйл ажиллагаатай холбогдуулан дараах баримт бичгийг энэ тогтоолын хавсралтаар тус тус баталсугай. Үүнд:
 - 3.1. “Хорго Хайрхан” ХК-д “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх гэрээ /Хавсралт №1/;
 - 3.2. “Хорго Хайрхан” ХК-д “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх журам /Хавсралт №2/;
 - 3.3. “Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай журам” /Хавсралт №3/
4. Компанийг нэгтгэх замаар өөрчлөн зохион байгуулах үйл ажиллагаатай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж буй дараах асуудлуудыг дэмжиж, зөвшөөрсүгэй.
 - 4.1. Нэгдэж байгаа “Монгол Даатгал” ХХК-ийн хувьцааг “Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаанд 3.214 харьцаагаар хөрвүүлж, 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 113,764,962 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган “Монгол Даатгал”

“ХОРГО ХАЙРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

- ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч “Миллениум Секюритис Менежмент Лимитед” ХХК-д эзэмшүүлэх;
- 4.2. Биржийн бүртгэлийн шалгуур хангах зорилгоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 37,831,570 ширхэг хувьцаа нэмж гаргах;
- 4.3. Нэмж гаргасан хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдаж авах эрхийг эдлүүлэх;
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг /Хавсралт №4/-аар баталсугай.
6. Компанийн зарласан хувьцааны тоог нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 151,866,784 ширхгээр шинэчлэн тогтоож, дүрэмд тусгасугай.
7. Зарласан боловч гаргаагүй 37,831,570 ширхэг хувьцааг гүйлгээнд гаргах, санал болгох үнийг тогтоох эрхийг ТУЗ-д олгосугай.
8. Энэ тогтоолын 7-д заасан эрхийг хэрэгжүүлэхийн тулд ҮЦ33-ийн тухай хуулийн 10.12 болон 10.13-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.
9. Нэгтгэх үйл ажиллагааны хүрээнд компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах болон бүртгүүлэх, хадгалуулах, компанийн шинэчилсэн бүртгэлийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ч.Энх-Амгалан/-д, даатгагчийн эрх зүйн байдал, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл авахыг “Монгол Даатгал” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Т.Батзул/-д тус тус даалгасугай.
10. ХК-д нэгдэж, эрх үүрэг хариуцлагыг бүрэн шилжүүлж, дуусгалтын тайланг гаргасан “Монгол Даатгал” ХХК-ийг татан буулгаж, Улсын бүртгэлээс хасуулахыг “Монгол Даатгал” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Т.Батзул/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ГАНЧИМЭГ